БАТЛАВ:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.МӨНХБАТ

ШААРДЛАГА ХАНГАСАН САЙЖРУУЛСАН ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ /ДУНДГОВЬ/ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАН, УГСРАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар: 17/2022 Мандалговь хот

1	Зураг, төсөл, угсралтын ажлыг гүйцэтгэх үндэслэл	- Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг; - Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2022 оны 22/05 тогтоолоор батлсан Орчны бохирдлыг бууруулахад 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө; - Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны даргын 2022 оны А/17 дугаар тушаал;
2	Барилга байгууламжийн байршил	Дундговь аймгийн Сайнцагаан сум
3	Зориулалт, хүчин чадал	50 мянган тонны хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэр
4	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар батлсан 2,000,000,000 төгрөг.
5	Захиалагч байгууллага:	Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;
7	Гүйцэтгэх ажил	Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутагт жилд 50 мянган тонны хүчин чадалтай сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулан батлуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг материалыг ханган нийлүүлж, барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.
8	Хийж гүйцэтгэх ажлууд:	1. <u>Инженерийн тооцоо, зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах, батлуулах:</u> 1.1. 2-3 нүүрсний ордын нүүрсний шинж чанарын судалгааг хийж шахмал түлшний 2019 онд батлагдсан стандартад нийцэх нүүрсний түүхий эдийг тодорхойлох. 1.2. 2-3 төрлийн тоног төхөөрөмжүүдийн хооронд харьцуулалт хийж, эдийн засгийн хувьд хамгийн ашигтайг нь тодорхойлох.

		1.3. Ажлын зураг, төсөв гаргах, улсын экспертизээр батлуулна. 1.4. Байгаль орчны ерөнхий, нарийвчилсан үнэлгээг хийнэ. 2. Ханган нийлүүлэлт: 2.1. ТЭЗҮ-д тусгагдсан тоног төхөөрөмж, сэлбэг материалыг заасан хугацаанд санхүүжилтийн хуваарийн дагуу ханган нийлүүлнэ. 3. Барилга угсралт: 3.1. Газар шорооны ажил 3.2. Суурийн ажил 3.3. Барилга угсралтын ажил 3.4. Тоног төхөөрөмжийн угсралт 3.5. Гадна цахилгаан хангамжийн ажил 3.6. Дотор цахилгаан, гэрэлтүүлэг 3.7. Халаалт, агаар сэлгэлтийн ажил 3.8. Сангийн ажил
9	Инженерийн шугам сүлжээ, түүний хангах эх үүсвэр	Эх загвар зурагт үндэслэн ачаалал тооцож, хангагч байгууллагуудаас шинээр техникийн нөхцөлүүдийг гаргуулна. Тус техникийн нөхцөлүүдийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний зураг, төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн батлуулан угсралтын ажлыг гүйцэтгэх.
10	Зураг, төсөл, угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллага	Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд;
11	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, задруулахгүй байх асуудлыг холбогдох хууль, журмаар зохицуулна.
12	Онцгой нөхцөл	Барилга байгууламж: - Газар хөдлөлийн 8 баллд төлөвлөх; - Эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал бага байх; - Барилгын фасад тухайн орчиндоо өнгө үзэмж нэмэхүйц, удаан эдэлгээтэй шийдэлтэй байх; Гадна талбай: - Гадна пандус, шат, довжоог өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах; - Борооны ус зайлуулах байгууламжийг өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх; Инженерийн шугам сүлжээ:

		- Эдэлбэр газарт газрын зургийн тодруулалт хийлгэх, газар доорх болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах; - Инженерийн шугам сүлжээний техникийн нөхцөлийн дагуу нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд буулгалт болон нөхөн сэргээлт, зөөж шилжүүлэх ажлыг зураг төсөвт тусгах; - Агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу төлөвлөх; - Ослын гэрэлтүүлгийг орц, гарц, коридорт төлөвлөх; - Тус барилгад розетка /ХТ/ төлөвлөхдөө норм, стандартыг мөрдөх; - Халаах хэрэгслийг М-140 маркийн ширмэн радиатор сонгох;
13	Галын аюулгүй байдлын нөхцөл	- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21-02-02/; - Барилга байгууламжийн галын аюулгүй байдал /БНбД 21-01-02/; - Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 4244:1994
14	Эдийн засгийн тооцоо төсөв	- Барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12*/2020; - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох;

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА Н.ЭРДЭНЭ-ОЧИР
АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА Ч.ЧАГНААДОРЖ
БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА Э.ЭНХМЭНД
АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХЗУЛ